

Нийгмийн Ардчилал Монголын Эмэгтэйчүүдийн Холбооны VI чуулганаар батлав.

НИЙГМИЙН АРДЧИЛАЛ МОНГОЛЫН ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ХОЛБООНЫ ДҮРЭМ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Нэгдүгээр зүйл. Дүрмийн зорилго, НАМЭХ-ны бэлгэдэл

- 1.1. Энэхүү дүрмийн зорилго нь Нийгмийн Ардчилал Монголын Эмэгтэйчүүдийн Холбоо /НАМЭХ/ -ны эрхэм зорилго, үйл ажиллагааны зарчим, бүтэц зохион байгуулалт, хяналт, удирдлагын болон гишүүд, дэмжигчдийн эрх үүрэгтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.
- 1.2. НАМЭХ нь Монгол Улсын тусгаар тогтнол, эрх чөлөө, шударга ёс, эв нэгдэл, үндэсний язгуур эрх ашгийг эрхэмлэн дээдэлсэн нийгмийн ардчиллын /социал демократ/ үзэл баримтлал бүхий зүүн төвийн нам-Монгол Ардын намын дэргэдэх эмэгтэйчүүдийн нийгэмд үйлчилдэг, ашгийн бус төрийн бус байгууллага мөн.
- 1.3. НАМЭХ нь Үндсэн хууль, бусад хууль тогтоомж, Монгол Ардын Намын үндсэн ба ёс зүйн дүрэм болон энэхүү дүрэмд нийцүүлэн үйл ажиллагаагаа явуулна.
- 1.4. НАМЭХ нь бэлгэ тэмдэг, сүлд дуу, тэмдэг, далбаа, хэвлэмэл хуудастай байна.

Хоёрдугаар зүйл. Холбооны эрхэм зорилго, үйл ажиллагааны зарчим,

үндсэн чиглэл

- 2.1. НАМЭХ-ны эрхэм зорилго нь Монгол Ардын Намын эрхэм зорилго, Хичээн эрмэлзэх зүйлийг хэрэгжүүлэхэд өөрийн гишүүдээ татан оролцуулж дэмжих, намын үзэл баримтлал, үйл хэргийг сурталчлан таниулах, иргэдэд тустай олон нийтийн ажлыг зохион байгуулан, жендэрийн эрх тэгш байдлыг хангах бодлого боловсруулж, эмэгтэйчүүдийн нийтлэг эрх ашгийг илэрхийлэн, улс орны болон нийгмийн хөгжил дэвшилд эмэгтэйчүүдийн эрх тэгш байдлыг хангах нөхцөлийг бүрдүүлэхэд оршино.
- 2.2. НАМЭХ үйл ажиллагаандаа хамтын удирдлага, эв нэгдэл, дотоод ардчилал, шударга өрсөлдөөний зарчмыг баримтлан, ил тод нээлттэй байдлыг эрхэмлэнэ.
- 2.3. Үйл ажиллагааны үндсэн чиглэл
 - 2.3.1. НАМЭХ нь эмэгтэйчүүдийн нийтлэг эрх ашгийг хамгаалах, жендэрийн эрх тэгш байдлын бодлого төлөвлөлт, хэрэгжилтийг хангахад гишүүд дэмжигчдээ оролцуулах, намын үзэл баримтлал, үйл хэргийг сурталчлан таниулахад дэмжлэг үзүүлэх,

- 2.3.2. Монгол Ардын Намын хичээн эрмэлзэх зүйл, сонгуулийн мөрийн хөтөлбөр, УИХ, Засгийн газрын бодлого шийдвэрийг боловсруулахад санал хүргүүлэх, тэдгээрийг сурталчлах, хэрэгжүүлэхэд идэвхтэй оролцох,
- 2.3.3. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах, шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн төлөөллийг нэмэгдүүлэх зорилгоор эмэгтэйчүүдийг сургах, дадлагажуулах ажлыг нэгдсэн бодлогын үндсэн дээр алсын хараатай, үе шаттай зохион байгуулах,
- 2.3.4. Намын гишүүн эмэгтэйчүүдийн судалгааг салбар бүрээр гаргаж, түүнд тулгуурлан хүний нөөцийн санг тогтмол баяжуулах ба намын бүх шатны сонгуульт байгууллагад болон намаас санал болгон сонгогдох, томилогдох албан тушаалд эмэгтэйчүүдийн квотыг хангах, шагнал урамшуулалд нэр дэвшүүлэх асуудлыг намын дүрмийн хүрээнд зохион байгуулах,
- 2.3.5. Хүний эрх, ногоон хөгжил, байгаль хамгаалал, иргэдийн соёл боловсрол, биеийн тамир спортын болон эмэгтэйчүүдийн нийтлэг эрх ашгийг хамгаалах чиглэлээр иргэний нийгэм, олон улсын байгууллага, гадаад, дотоодын болон бусад байгууллагатай нягт хамтран ажиллах, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх.

ХОЁРДУГААР БҮЛЭГ. НАМЭХ-НЫ ГИШҮҮНЧЛЭЛ, БҮТЭЦ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Гуравдугаар зүйл. НАМЭХ-ны гишүүнчлэл

- 3.1. НАМЭХ-ны эрхэм зорилго, дүрмийг хүлээн зөвшөөрч, үйл ажиллагааг дэмжихээ илэрхийлсэн Монгол Улсын иргэн эмэгтэй нас, яс үндэс, боловсрол, ажил мэргэжлийг үл ялгаварлах зарчмаар гишүүнээр элсэн орж болно.
- 3.2. НАМЭХ-ны үйл ажиллагааг дэмжихээ илэрхийлсэн эрэгтэй, эмэгтэй хэн боловч холбооны дэмжигч байж болно.
- 3.3. Мэргэжил сонирхлын бүлэг, эмэгтэйчүүдийн бусад байгууллага, хөдөлгөөн, оюутны клуб, дугуйлан нь тус холбооны гишүүн байгууллага байж болно. Гишүүн байгууллага элсүүлэх асуудлыг НАМЭХ-ны төв, салбар холбоо, зөвлөлийн удирдах байгууллагын хурлаар хэлэлцэж шийдвэрлэнэ.

Дөрөвдүгээр зүйл. НАМЭХ-ны бүтэц зохион байгуулалт

- 4.1. НАМЭХ нь дараах бүтэцтэйгээр үйл ажиллагаагаа явуулна. Үүнд:
- 4.1.1. НАМЭХ-ны Чуулган,
 - 4.1.2. НАМЭХ-ны Ерөнхийлөгч,
 - 4.1.3. НАМЭХ-ны Удирдах Зөвлөл,
 - 4.1.4. НАМЭХ-ны Дэд Ерөнхийлөгч, Хүндэт Ерөнхийлөгч,

- 4.1.5. НАМЭХ-ны Ажлын албаны дарга,
- 4.1.6. НАМЭХ-ны салбар холбоо, зөвлөлүүд,
- 4.1.7. Хяналтын хороо, хэсэг,
- 4.1.8. Мэргэжил сонирхлын бүлэг, клуб, хамтлаг, сан, бичил сургалтын төв, төслийн нэгж, дугуйлантай байж болох бөгөөд журмыг Удирдах зөвлөл тогтооно.
- 4.1.9. НАМЭХ нь өөрийн хэвлэлтэй байж болно.

4.2. НАМЭХ-ны Чуулган

- 4.2.1. НАМЭХ-ны удирдах дээд байгууллага нь чуулган байна. Чуулган 4 жилд нэг удаа хуралдана.
- 4.2.2. Чуулганы бүрэн эрх:
 - 4.2.2.1. НАМЭХ-ны бодлого, үйл ажиллагааны үндсэн чиглэлийг батлах,
 - 4.2.2.2. НАМЭХ-ны дүрэм, холбогдох журам, бодлогын чиглэлийг хэлэлцэн батлах, нэмэлт өөрчлөлт оруулах,
 - 4.2.2.3. Хөрөнгө санхүүгийн бүрдүүлэлт, зарцуулалт, зориулалтыг батлах, түүний гүйцэтгэлийг хэлэлцэн батлах,
 - 4.2.2.4. Холбооны Ерөнхийлөгчийг сонгох,
 - 4.2.2.5. Хяналтын хорооны дарга, гишүүдийг 5-7 хүний бүрэлдэхүүнтэй сонгох, чөлөөлөх,
 - 4.2.2.6. Ерөнхийлөгчийн тайлан илтгэлийг хэлэлцэх,
 - 4.2.2.7. Хяналтын хорооны тайланг хэлэлцэх, батлах,
 - 4.2.2.8. Хүндэт Ерөнхийлөгчид өргөмжлөх асуудлыг хэлэлцэн батлах,
 - 4.2.2.9. НАМЭХ-г өөрчлөн байгуулах, татан буулгах,
 - 4.2.2.10. Бусад асуудал.
- 4.2.3. Чуулганы төлөөлөгчдийг холбооны 300 гишүүн дутмаас 1 төлөөлөгч байхаар тооцож, аймаг, нийслэлийн салбар холбоо, сум, дүүрэг, баг, хорооны салбар зөвлөлийн чуулганаас сонгоно.
- 4.2.4. Чуулган нь сонгогдсон гишүүдийн олонхи ирснээр хүчин төгөлдөр болно.
- 4.2.5. Чуулганы гишүүдийн олонхийн саналаар асуудлыг шийдвэрлэнэ.
- 4.2.6. Шийдвэрийг тогтоол хэлбэрээр баталгаажуулна.
- 4.2.5. Чуулган нь зарим бүрэн эрхээ Удирдах Зөвлөлд шилжүүлж болно.

4.3. НАМЭХ-ны Ерөнхийлөгч

- 4.3.1. Ерөнхийлөгч нь НАМЭХ-ны Чуулганаар сонгогдох бөгөөд 1 удаа дахин сонгогдож болно. Ерөнхийлөгч нь зөвлөхүүдтэй байж болно.
- 4.3.2. МАН-ын дарга НАМЭХ-ны Ерөнхийлөгчид нэр дэвшигчийг Чуулганд танилцуулна.

4.3.3. НАМЭХ-ны Ерөнхийлөгчид нэр дэвшигчийг чуулганаараа нээлттэй хэлэлцэж, нууц санал хураалтын дүнгээр, олонхийн санал авсан нэр дэвшигчийг сонгоно.

4.3.4. НАМЭХ-ны Ерөнхийлөгч Намын Удирдах зөвлөлийн гишүүн байна.

4.3.5. Ерөнхийлөгчийн эрх, үүрэг:

4.3.5.1. НАМЭХ-ны Чуулганаас батлагдсан үзэл баримтлал, бодлогыг хэрэгжүүлэх,

4.3.5.2. Удирдах зөвлөлийн хурлыг даргалах,

4.3.5.3. Чуулганы хооронд НАМЭХ-ны үйл ажиллагааг удирдлагаар хангах,

4.3.5.4. Шаардлагатай тохиолдолд ээлжит бус Чуулганыг зарлан хуралдуулах саналыг Удирдах Зөвлөлд оруулах,

4.3.5.5. НАМЭХ-ны Удирдах зөвлөлийн гишүүд, Дэд ерөнхийлөгчид нэр дэвшүүлэх, чөлөөлөх саналыг Чуулганд оруулах,

4.3.5.6. НАМЭХ-г дотоод, гадаадад бүрэн эрхтэйгээр төлөөлөх,

4.3.5.7. НАМЭХ-ны Ерөнхийлөгч өөрийн эзгүйд болон хүндэтгэн үзэх шалтгаанаар албан үүргээ гүйцэтгэх боломжгүй болсон тохиолдолд Дэд ерөнхийлөгчид орлон гүйцэтгүүлэхээр Удирдах зөвлөлд санал оруулах ба тогтоолоор баталгаажуулна.

4.4. НАМЭХ-ны Удирдах Зөвлөл

4.4.1. Чуулганы хооронд Холбооны үйл ажиллагааг зохион байгуулах үүрэгтэй Удирдах Зөвлөл 21-29 хүний бүрэлдэхүүнтэй байна.

4.4.2. Удирдах Зөвлөлийн эрх үүрэг:

4.4.2.1. Удирдах Зөвлөл нь холбооны бодлого, үйл ажиллагааны ойрын чиглэлийг тодорхойлно.

4.4.2.2. Холбооны жил, улирлын төлөвлөгөө, түүний гүйцэтгэлийг хэлэлцэн баталж, хяналт тавина.

4.4.2.3. Холбооны ажлын албаны бүтэц, зохион байгуулалт, орон тоо, ажил үүргийн хуваарийг хэлэлцэн батална.

4.4.2.4. Холбооны төсөв, санхүүжилтийг бүрдүүлж, гүйцэтгэлд хяналт тавина.

4.4.2.5. Чуулган, Удирдах зөвлөлийн хуралдааны дэгийг батлана.

4.4.2.6. Холбооны гишүүний татвар, сонгуульт гишүүний хураамж, хандивын хэмжээ, журмыг тогтооно.

4.4.2.7. Сонгуульт гишүүнд болон хяналтын хороо, хэсэгт нэр дэвшүүлэх шалгуурыг тогтоон, мөрдүүлнэ.

4.4.2.8. Ажлын албаны даргын тайланг хэлэлцэнэ.

4.4.2.9. Гишүүн хүндэтгэх шалтгаангүйгээр Удирдах зөвлөлийн хуралд 4 удаа оролцоогүй бол шууд чөлөөлөгдөнө. Энэ тохиолдолд нөхөн сонгох

асуудлыг Удирдах зөвлөл шийдвэрлэнэ.

4.4.2.10. Бусад асуудал.

4.5. НАМЭХ-ны Дэд Ерөнхийлөгч, Нарийн бичгийн дарга

4.5.1. НАМЭХ нь нэг Дэд ерөнхийлөгчтэй байна.

4.5.2. Дэд ерөнхийлөгчийг Ерөнхийлөгчийн санал болгосноор НАМЭХ-ны Чуулганаас сонгож чөлөөлнө.

4.5.3. НАМЭХ нь 5 Нарийн бичгийн даргатай байна.

4.5.4. Нарийн бичгийн дарга нар зүүн, төв, хангай, баруун, Улаанбаатарын бүсийг хариуцан ажиллана. Тэдгээрийн үйл ажиллагааны чиглэлийг нарийвчлан Удирдах зөвлөлийн хурлаар батална.

4.6. Хүндэт Ерөнхийлөгч

4.6.1. НАМЭХ нь тус байгууллагад олон жил үр бүтээлтэй ажиллаж, Холбооны үйл ажиллагааг олонд таниулан хүлээн зөвшөөрүүлж, гадаад, дотоод харилцааг өргөжүүлэн, байгууллагын нэр хүндийг өргөж ажилласан Ерөнхийлөгчийг Хүндэт Ерөнхийлөгчид өргөмжилж болно.

4.7. НАМЭХ-ны ажлын алба

4.7.1. НАМЭХ-ны өдөр тутмын үйл ажиллагааг эрхлэн явуулах ажлын албатай байна.

4.7.2. Ажлын албаны бүтэц, үйл ажиллагаа явуулах журмыг Удирдах зөвлөл батална.

4.7.3. НАМЭХ-ны Ажлын албаны даргыг Ерөнхийлөгчийн санал болгосноор Удирдах Зөвлөл томилж, чөлөөлнө.

4.7.4. НАМЭХ-ны Ажлын албаны даргын эрх, үүрэг:

4.7.4.1. Удирдах зөвлөлийн хурлын бэлтгэлийг хангах, гарсан шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах,

4.7.4.2. НАМЭХ-ны санхүү, аж ахуйг эрхлэн хөтлөх, батлагдсан төсвийг захиран зарцуулах,

4.7.4.3. НАМЭХ -ны архив, албан хэргийг зохих журмын дагуу эрхлэн хөтлөх,

4.7.4.4. Ажлын албаны орон тооны ажилтнуудын ажил үүргийн биелэлтэд хяналт тавьж ажиллах,

4.7.4.5. Мэргэжил сонирхлын бүлэг, хамтлаг, сан, бичил сургалтын төв, клуб, дугуйлан, төслийн нэгжийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулна.

4.8. Салбар холбоо, зөвлөл

4.8.1. НАМЭХ-ны орон нутгийн салбар холбоо, зөвлөл нь нутаг дэвсгэрийн зарчмаар байгуулагдана. Гадаад улс оронд салбар холбоо, зөвлөл байгуулан ажиллуулж болно.

Тавдугаар зүйл. НАМЭХ-ны аймаг, нийслэлийн салбар холбоо, сум, дүүрэг, баг, хорооны салбар зөвлөл

- 5.1. Аймаг, нийслэлийн салбар холбоо, сум, дүүрэг, баг, хорооны салбар зөвлөлийн удирдах дээд байгууллага нь чуулган, түүний чөлөөт цагт Тэргүүлэгчдийн хурал байна.
- 5.2. Салбар холбоо, зөвлөлийн Чуулган нь 4 жилд 1 удаа хуралдана. Шаардлагатай тохиолдолд ээлжит бус чуулганыг зарлан хуралдуулж болно.

5.3. Чуулган нь дараах бүрэн эрхтэй байна.

- 5.3.1. Салбар холбоо, зөвлөлийн даргын тайлан, илтгэлийг хэлэлцэх,
- 5.3.2. Салбар холбоо, зөвлөлийн хяналтын хороо, хэсгийн тайланг хэлэлцэх,
- 5.3.3. Салбар холбоо, зөвлөлийн даргыг сонгох, чөлөөлөх.
- 5.3.4. НАМЭХ-ны Удирдах зөвлөл нь Салбар холбооны даргыг, Салбар холбооны Тэргүүлэгчид нь салбар зөвлөлийн даргыг тухайн шатны МАН-ын хороотой зөвшилцөн чуулганд нэр дэвшүүлнэ.
- 5.3.5. Салбар холбоо, зөвлөлийн дарга нь тухайн шатны МАН-ын хороо, үүрийн тэргүүлэгч байна.
- 5.3.6. Салбар холбоо, зөвлөлийн үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлох,
- 5.3.7. Салбар холбоо, зөвлөлийн тэргүүлэгчдийг Салбар холбоо, зөвлөлийн дарга чуулганд санал болгосноор 5-19 хүртэл хүний бүрэлдэхүүнтэйгээр сонгох,
- 5.3.8. Салбар холбоо, зөвлөлийн Хяналтын хороо, хэсгийг 3-7 хүний бүрэлдэхүүнтэй байгуулах,
- 5.3.9. Бусад асуудал.

5.4. Салбар холбоо, зөвлөлийн даргын эрх үүрэг:

- 5.4.1. Тэргүүлэгчдийн хурлыг даргалах,
- 5.4.2. Чуулганы хооронд Салбар холбоо, зөвлөлийн үйл ажиллагааг удирдлагаар хангах,
- 5.4.3. Салбар холбоо, зөвлөлийг төлөөлөх,
- 5.4.4. Салбар холбоо, зөвлөлийн Тэргүүлэгчдийн бүрэлдэхүүнийг Чуулганд нэр дэвшүүлэх.

5.5. Салбар холбоо, зөвлөлийн тэргүүлэгчдийн бүрэн эрх:

- 5.5.1. Чуулганы хооронд Салбар холбоо, зөвлөлийн үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлох,
- 5.5.2. Чуулганы товыг зарлан, хуралдуулах,
- 5.5.3. Орон гарсан тохиолдолд Тэргүүлэгчдийн дийлэнх олонхийн саналаар Тэргүүлэгч гишүүнийг сонгох,
- 5.5.4. Салбар холбоо, зөвлөлийн ажлын албаны даргыг сонгох, чөлөөлөх,
- 5.5.5. Бусад асуудал.

Зургаадугаар зүйл. Мэргэжил сонирхлын бүлэг, клуб, хамтлаг, сан, сургалтын төв, төслийн нэгж, дугуйлан

- 6.1. НАМЭХ нь гишүүн байгууллага, гишүүд, дэмжигчиддээ түшиглэн олон нийтэд хүрч нөлөөлөх зорилгоор мэргэжил сонирхлын бүлэг, клуб, хамтлаг, сан, сургалтын төв, төслийн нэгж, дугуйланг ажиллуулж болно.
- 6.2. Мэргэжил сонирхлын бүлэг, клуб, хамтлаг, сан, сургалтын төв, төслийн нэгж, дугуйлан нь нийгмийн сайн сайхны төлөөх зорилгоор ажиллаж, НАМЭХ-ны төв, орон нутгийн удирдах байгууллагад ажлаа тайлагнана.
- 6.3. Нам ба НАМЭХ-ноос эдгээрт санхүүгийн дэмжлэг үзүүлж болно.

ГУРАВДУГААР БҮЛЭГ. НАМЭХ-НЫ ХЯНАЛТ

Долоодугаар зүйл. НАМЭХ-ны Хяналтын хороо, хэсэг, түүний бүрэн эрх

- 7.1. Хяналтын хороо, хэсэг нь НАМЭХ-ны болон удирдлагын үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллах ба хараат бус дотоод хяналтын үүргийг хэрэгжүүлнэ.
- 7.2. Аймаг, нийслэлийн салбар холбооны Хяналтын хороо 5-7 хүний бүрэлдэхүүнтэй ажиллана.
- 7.3. Сум, дүүрэг, баг, хорооны салбар зөвлөлийн Хяналтын хэсэг 3-5 хүний бүрэлдэхүүнтэй ажиллана.
- 7.4. НАМЭХ -ны Хяналтын хороо, хэсгийн гишүүдийг Чуулганаас сонгоно.
- 7.5. Хяналтын хороо, хэсэг нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:
 - 7.5.1. НАМЭХ-ны болон удирдлагын үйл ажиллагаанд хяналт тавих,
 - 7.5.2. Холбооны дүрмийн хэрэгжилтэд хяналт тавих,
 - 7.5.3. Өмч хөрөнгийн ашиглалт, санхүүгийн үйл ажиллагаанд хяналт тавих,
 - 7.5.4. Бичиг хэрэг, архивын бүрдэлтэд хяналт тавьж, шалган зөвлөж ажиллах,
 - 7.5.5. Хяналтын хороо, хэсэг нь ажлаа чуулганд тайлагнана.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. БУСАД АСУУДАЛ

Наймдугаар зүйл. Хуралдаанаас шийдвэр гаргах журам

- 8.1. НАМЭХ-ны Чуулган, Удирдах байгууллагын хуралдааныг түүний бүрэлдэхүүний олонхи ирснээр хүчин төгөлдөр гэж үзнэ.
- 8.2. Хурал, чуулганы шийдвэрийг түүнд оролцогчдын олонхийн саналаар батална.
- 8.3. Удирдах байгууллагын гишүүд аливаа асуудлыг шийдвэрлэхэд тэгш эрхтэй оролцоно.

- 8.4. Удирдах байгууллага нь хувь хүний асуудлыг нууцаар, бусад асуудлыг илээр санал хураах зарчмаар шийдвэрлэнэ.
- 8.5. Хуралдаанаас тогтоол, протокол гаргана.

Есдүгээр зүйл. НАМЭХ-ны өмч хөрөнгө

- 9.1. НАМЭХ-ны өмч хөрөнгө нь түүний бүх шатны болон харъяа байгууллагын оюуны болон материаллаг өмч хөрөнгөөс бүрдэнэ.
- 9.2. НАМЭХ нь дараах эх үүсвэрээр санхүүжнэ.
- 9.2.1. Намын санхүүгийн дэмжлэг, санхүүжилт,
 - 9.2.2. Дүрмийн хүрээнд явуулсан үйл ажиллагааны орлого,
 - 9.2.3. Дотоод, гадаадын дэмжигч байгууллага, хувь хүн, гишүүдийн хандив, татвар, хураамж, хөрөнгө оруулалт,
 - 9.2.4. НАМЭХ-ны өрнүүлсэн хөдөлгөөн, түүнээс олсон биет болон биет бус орлого,
 - 9.2.5. Хуулиар зөвшөөрсөн бусад орлого.
- 9.3. НАМЭХ-ны Удирдах зөвлөлөөс гишүүдийн татвар, хураамж болон санхүүжилтын журмыг батална.
- 9.4. НАМЭХ-ны санхүүгийн үйл ажиллагааг Ажлын албаны даргын удирдлагад ажиллах санхүүч хариуцан ажиллана.

Аравдугаар зүйл. НАМЭХ-г өөрчлөн байгуулах, татан буулгах

- 10.1. НАМЭХ нь өөрчлөн байгуулагдсан, татан буугдсан тохиолдолд, түүний хариуцвал зохих төлбөрийг хийсний дараа үлдсэн эд хөрөнгийг түүний үйл ажиллагааг залгамжилсан байгууллага буюу түүний дүрэмд нийцсэн үйл ажиллагаанд зориулан зарцуулна.
- 10.2. Өөрчлөн байгуулагдсан, татан буулгасан тухай шийдвэрээ 21 хоногийн дотор нийтэд мэдээлж, төрийн бус байгууллагын бүртгэлийн газарт бичгээр мэдэгдэнэ.

НАМЭХ-НЫ VI ЧУУЛГАН

2014.01.17

УЛААНБААТАР ХОТ